

## Интернэт ПИН код гэж юу вэ?

ХХБанк нь Verified by VISA технологийг ашиглаж интернэтээр бараа үйлчилгээ худалдан авах боломжийг өөрсдийн харилцагч нарт олгож байгаа билээ. Карт эзэмшигч нар нь ХХБ-тай гэрээ бүхий интернэт үйлчилгээний байгууллагын дэлгүүрээр худалдан авалт хийхэд АТМ болон Банкны ПС Теллерээс авсан тусгай нууц дугаарыг ашиглах шаардлагатай байдаг. Энэ нууц дугаарыг интернэт ПИН код гэх бөгөөд Карт эзэмшигч өөрөө дурын 4 тоо сонгон АТМ-ээс авах боломжтой юм.


## Интернэт ПИН кодыг хэрхэн авах вэ?

Интернэт ПИН кодыг АТМ-ээс дараах дарааллын дагуу авна.


1. Нууц дугаар солих цэс руу орно.




2. Интернэт ПИН код солих цэс руу орно




3. Тухайн картаар анх удаа авч байгаа тохиолдолд хуучин ПИН код оруулах хэсэг дээр АТМ-ээс мөнгө авах зориулалт бүхий кодоо хийнэ. Хуучин интернэт ПИН кодоо солих тохиолдолд хуучин ПИН кодыг оруулна.



4. Шинэ Интернэт ПИН кодоо сонгож 4 оронтой тоо хийнэ.



5. Сонгосон тоогоо баталгаажуулна.



Санамж: Карт эзэмшигч хүссэн цагтаа интернэт ПИН кодоо солиж болох бөгөөд нууцлалыг чандлан хадгалж байх үүргийг хүлээнэ.

VBV гэж юу вэ?

[http://www.bankcard.mn/personal/online\\_vbv\\_index.htm](http://www.bankcard.mn/personal/online_vbv_index.htm)